


**Шинэ коронавирүс (nCoV)-ийн
халдварын сэжигтэй тохиолдлоос
лабораторийн шинжилгээнд сорьц
цуглуулах, хадгалах, тээвэрлэх**

АУ-ы доктор Б.Дармаа



Coronaviridea бүлд хамаардаг,
нэг утаслаг РНХ агуулсан вирус.
Байгаль дээр олон төрөл зүйлийн
амьтанд
өргөн тархсан.

1. HCoV-229E,
2. HCoV-NL63,
3. HCoV-NKU1,
4. HCoV-OC43

гэсэн хүний 4 төрлийн коронавирүс дэлхий нийтэд хүнд нутагшмал тархалттай байдаг. Эдгээр нь хүний амьсгалын замд шинж тэмдэггүй, хөнгөн явцтайгаас хүнд хэлбэрийн хүртэл өвчлөл үүсгэдэг.

5. SARS CoV нь 2002 онд суусар болон агуйн сарьсан багваахайнаас,

6. SARS-CoV нь 2012 онд нэг бөхт тэмээнээс хүнд халдаж хүнд хэлбэрийн өвчлөл үүсгэсэн

7. 2019-nCoV 2019 оны 12 сард БНХАУ-ын Ухань хотод дэгдэлт үүсгэж бүртгэгдсэн. Геномын дарааллын 80% нь SARS-CoV –тэй төстэй гэсэн мэдээлэл байна.

Сорьцын төрөл	Сорьц цуглуулах хэрэгсэл	Тээвэрлэлтийн горим	Шинжилгээ хийх хүртэл хадгалах горим
Хамар-залгиур/ам-залгиурын арчдас хамт	<ul style="list-style-type: none"> • Дакрон буюу мяндсан сойз бүхий ариун бамбар • Вирүс тээвэрлэх орчин 	4 ⁰ С	≤5 хоног: 4 ⁰ С >5 хоног: -70 ⁰ С
Гуурсан хоолой-цулцангийн угаадас/шингэн	Ариун сав	4 ⁰ С	≤48 цаг: 4 ⁰ С >48 цаг: -70 ⁰ С
Мөгөөрсөн хоолойн сордос, хамар-залгиурын сордос буюу хамрын угаадас	Ариун сав	4 ⁰ С	≤48 цаг: 4 ⁰ С >48 цаг: -70 ⁰ С
Цэр	Ариун сав	4 ⁰ С	≤48 цаг: 4 ⁰ С >48 цаг: -70 ⁰ С
Биопси буюу аутопси үед авсан эд	Ариун сав Вирүс тээвэрлэх орчин, Сорьцноос нян өсгөвөрлөх бол ариун физиологийн уусмал	4 ⁰ С	≤24 цаг: 4 ⁰ С >24 цаг: -70 ⁰ С
Ийлдэс (2 удаагийн сорьц авна – өвчний цочмог ба эдгэрэлтийн үед буюу цочмог үе өнгөрснөөс хойш 2-4 долоо хоногийн дараа)	Ийлдэс ялгах хуруу шил (насанд хүрэгчид: 3-5 мл бүхэл цус цуглуулна)	4 ⁰ С	≤5 хоног: 4 ⁰ С >5 хоног: -70 ⁰ С


- Вирус илрүүлэх шинжилгээнд аль болох **олон төрлийн сорьц цуглуулах** тусмаа ач холбогдолтой: УЧИР НЬ: Уг вирус нь хүний популяцад түгээмэл тархах чадвараа олж хараахан чадаагүй тул хүний сорьцонд бага титртэйгээр илэрч байна.
- **Дараалсан хэд хэдэн өдөр ижил сорьц давтан цуглуулна**
- Амьсгалын дээд ба доод хэсгээс байвал сайн: Хамар залгиурын арчдас, хамар угаасан шингэн, хоолойн арчдас, ам залгиур хоолойн арчдас зэргийг өөр өөр бамбараар цуглуулж нэг, эсвэл тус тусад нь саванд хийнэ
- Өвчтөн уушгины хатгалгаа болон амьсгалын доод хэсгийн үрэвслийн шинжтэй бол дээрхи сорьцноос гадна бронх алвеолын лаважи, трахейн аспират, бронх угаасан шингэн авна. **Зөвхөн интубацитай өвчтөн эсвэл бронхыг дурандах ажилбар хийгдэж байгаа бол энэ төрлийн сорьц авна**

Хамар залгиурын арчдас авах

Амьсгалын дээд замын сорьц- эпители эсийг аль болох оролцуулан авах нь чухал.


Хамар залгиурын арчдасыг авахдаа:

- Үйлчлүүлэгчийн хамрын хөндийг арчиж цэвэрлүүлж шинжилгээнд бэлтгэнэ
- Зүүн гарын долоовор хуруугаар хамрын үзүүрийг өргөж бамбар шургуулах замыг чөлөөлнө
- Ариун бамбарыг хамрын хөндий рүү 2-3 мс хүртэл шургуулж 6-8 удаа эргүүлэх хөдөлгөөнөөр арчдас авна.
- Арчдас бүхий бамбарыг вирүс тээвэрлэх орчин бүхий саванд хийнэ
- Ажилбарыг алв болох шуурхай гүйцэтгэх шаардлагатай



- Бага насны хүүхдээс сорьц авахдаа асран хамгаалагчид нь хөдөлгөөнгүй тэврүүлэн суулгана.
- Асран хамгаалагч нэг гарын алгаар хүүхдийн духнаас нь арагш цээжрүүгээ шахаж, нөгөө гараар хүүхдийг цээжээр нь тэвэрч сууна
- Хүүхдээс сорьц авахад уян бамбарыг ашиглавал зохимжтой
- Ажилбарыг аль болох шуурхай гүйцэтгэнэ

Вирүс тээвэрлэх орчин



Энэ нь вирусийг тодорхой хугацаанд амьд байх нөхцлийг хангадаг тэжээл юм.

1. Давсны уусмал- Ионы конц.тогтмол байлгана.
2. Indicator- буфер
3. Вирүс тогтвортой байлгах уургууд
4. Антибиотик- Бактер, Мөөгөнцөрийн халдвараас сэргийлнэ.

Арчдас авах бамбар



Сорьц агуулсан **саван дээр заавал тэмдэглээ** хийж, дагалдах хуудсыг бүрэн бөглөнө.

Цуглуулсан он, сар, өдөр хамгийн чухал

Аюулгүй байдлыг ханган боох, тээвэрлэлтэнд өгөх:

Сорьц бүхий савыг ариутгалын уусмалаар арчаад бөглөөг сайн чангалж, парафильм цаасаар орооно. Гадуур нь шингээгч цаасаар орооно. Дагалдах хуудсыг хавсаргана.

Сорьц №...../.....

Регистрийн дугаар: _____ FIS дугаар: _____

Эрүүл мэндийн байгууллагын нэр: _____

Өвчтөний овог/нэр: _____

Нас: _____ Хүйс: эрэгтэй эмэгтэй

Гэрийн хаяг: _____

Эмнэлзүйн онош: _____

Өвчин эхэлсэн: _____ он _____ сар _____ өдөр

Эмнэлэгт хэвтсэн: _____ он _____ сар _____ өдөр

Сорьц авсан: _____ он _____ сар _____ өдөр _____ цаг _____ мин

Сорьц авах үеийн биеийн хэм: _____

Томуугийн вакцин хийлгэсэн эсэх: тийм үгүй мэдэхгүй

Тийм бол огноо: _____ он _____ сар _____ өдөр

Вирүсийн эсрэг эм хэргэлсэн эсэх: тийм үгүй мэдэхгүй

Жирэмсэн эсэх: тийм үгүй мэдэхгүй

Архаг хуучтай эсэх. тийм үгүй мэдэхгүй

Тийм бол тодруулна уу: Амьсгалын замын архаг өвчин

Зүрхний өвчин Жин ихтэй Даралт ихсэх

Бөөрний өвчин Чихрийн шижин Дархлал дутлын

Бусад _____

Сорьцын төрөл: _____

Тээвэрлэлтэнд өгсөн: _____ он _____ сар _____ өдөр _____ цаг _____ мин

Сорьц авсан эмч, сувилагчийн нэр: _____

Шинжилгээний хариу: _____

Хадгалах:

- Лабораторит аль болох хурдан илгээнэ.
 - 48-72 цагийн дотор бол +4 хэмд,
 - Удаан хадгалах бол -70 хэмд хадгална
-
- -20 хэмд хөлдөөж болохгүй, мөсөн элемент бүхий саванд хийж хөлдөөхгүй!



Тээвэрлэх




- Сорьцийн дагалдах бичгийг үнэн зөв, гүйцэд бөглөнө.
- Сорьцийг ХӨСҮТ-ийн вирус судлалын лабораторт хэн, хэзээ, ямар тээврийн хэрэгслээр хүргэх тухай урьдчилан мэдэгдэнэ.
- (Утас № 11455847).

Анхаарах зүйл

- Сорьцын мэдээллийг цаг тухайд нь шивж оруулах (FIS)


← → ↻

nccd (nccd_lab) [Миний тохиргоо](#) | Эрх: Лаборант | Эмнэлэг: ХӨСҮТ/Улаанбаатар/Баянзүрх | [Гарах](#)



Монгол Улсын Эрүүл Мэндийн Яам
Халдварт өвчин судлалын үндэсний төв

ТОМУУГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ



[Сорьц](#) [Шинжилгээ](#) [Тайлан](#)

[Шинжилгээний жагсаалт](#) | [Шинжилгээний бүртгэл](#)

Түүвэрлэх сонголт

Эмнэлгийн байгууллагын нэр:

Регистрийн дугаар:

Эцэг/эх/-ийн нэр: Нэр:

Төрсөн огноо: -с -хүртэл Хүйс:

Сорьцын дугаар: Бүртгэсэн огноо: -с -хүртэл

Шинжилгээний дугаар:

Шинжилгээний Жагсаалт Хуудаслалт [« ≤ 1 - 2 - 3 - 4 - 5 »]

Илгээсэн эмнэлэг		Өвчтөний мэдээлэл				Сорьцын мэдээлэл					Шинжилгээний мэдээлэл				
Аймаг хот Сум дүүрэг	Байгууллага	Эцэг/эх Нэр	Э/З онош	Голомт	Өвчлөл Эхэлсэн	Сорьцын №	Төрөл	Огноо	Тээвэрлэсэн	Хүлээн авсан	Шинж/төрөл	Ерөнхий хариу	Дэлгэрэнгүй хариу	Огноо	Лаборатор
Улаанбаатар Багануур	Энэрэлт-Өлзий	Дорж Ариунзрдэнэ	ТӨ	Үгүй	2017/10/13	101734588	Хамар залгиурын арчдас	2017/10/16	2017/10/18						<input checked="" type="checkbox"/> <input type="checkbox"/>
Улаанбаатар	Баттүвшин						Хамар								<input type="checkbox"/> <input checked="" type="checkbox"/>

**Сорьц цуглуулахад халдвар
хамгаалал, аюулгүй байдал
хамгийн чухал**

Хувийн хамгаалах хэрэгсэл



Нүдний хамгаалалт



Mack



The collector must be using appropriate personal protective equipment



The first swab is collected from the nasopharynx – remember the nasal cavity goes “back” not “up”

Халад ба өмсгөл



Бээлий



Бээлий

□ Өмсөхийн өмнө шалга

- Бээлийн материал нь гэрэлд задарсан байж болзошгүй тул хадгалалтыг хяна, шалга
- Урагдсан, цоорсон, гандсан эсэхийг шалга
- Бээлийгээ өмсөхийн өмнө бөгж, цагаа авах ёстой: Учир нь бээлийг урж цоолж болзошгүй, халдвар тараах эрсдэл үүсгэж ч болзошгүй

□ Ажилбар бүрийн дараа бээлийгээ солих

□ Хог хаягдлын зориулалтын саванд хаях

□ Бохирдсон бээлийтэйгээ нүүрэндээ хүрэх, ХХХ-д хүрэлцэх, засч бүслэх, хаалга онгойлгох мэтийн үйлдэл хийхийг хориглоно!

Лабораторит хийгдэх шинжилгээ

- **Вирүст халдвар: томуугийн А, В вирус, аденовирус, хүний бусад коронавирүс, амьсгалын синцитиаль вирус, иж томуугийн вирус 1-4, хүний метапневмовирус, риновирус, энтеровирус, аденовирүс**
- **Нянгийн халдвар: Streptococcus pneumoniae, Haemophilus influenzae, Streptococcus pyogenes, Legionella pneumophila, Legionella non-pneumophila, боом, лептоспироз, Mycoplasma, Chlamydia pneumoniae ба psittaci, Ку чичрэг (Coxiella burneti), микобактерийн халдвар ба зарим өвчтөний бүлэгт илрэх Pneumocystis carinii–аар сэдээгдсэн хатгалгаа, мөөгөнцрийн халдвар зэрэг оппортунист халдвараас ялган оношилно.**
- **Эмнэлзүйн хамшинжээс хамаарч халдварын бус шалтгаан (ж.нь, хор, цацраг туяа)-ыг мөн харгалзан үзэх нь зүйтэй.**
- **Энэ шинэ коронавирүсийн генийн дарааллын мэдээг зарласан бөгөөд нуклеин хүчлийг олшруулах өвөрмөц оношлуурыг үйлдвэрүүдэд боловсруулж байна, Ойрын хугацаанд УТ-ПГУ-аар шинэ халдварыг баталгаажуулах боломжтой болно.**

Ашигласан материал

- 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас боловсруулан гаргасан түр удирдамжийг ашиглав.
- <https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/330374/WHO-2019-nCoV-laboratory-2020.1-eng.pdf>

***Анхаарал хандуулсанд
баярлалаа***

ТТӨ үүсгэгчийн тандалт одоогийн байдал

2019 оны 35 дахь 7 хоногоос 2020 оны 2 дахь 7 хоногт

Бүсийн лабораториудын вирус судлалын тандалт (2019/2020)

